



БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны ... дугаар сарын ... ны өдөр

КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР АВАХ ШАТАХУУНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад үйлчлэх хөдлөх бүрэлдэхүүний картаар авах шатахуунд тавигдах техникийн шаардлага болон төсөвт өртгийг тусгасан болно.

Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний чанарын MNS 0216:2017 /Евро-5 дизель түлш/ MNS-6861:2020 /Дизелийн түлш/, MNS 0217:2017 /Автомашинны бензин/ техникийн шаардлагын үзүүлэлтүүдийг хангаж байх.

2. ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

| Нэр | Хэмжигдэхүүн |
|---------------------------|--|
| Нийлүүлэлтийн төрөл | Шатахууны цахим картаар |
| Нийлүүлэх шатахууны төрөл | Дизель түлш /өвөл, завсрын улирал, зун /, Аи-92 автобензин, Аи-95 автобензин, Евро-5 дизель түлш |
| Хэмжих нэгж | Литр |
| Төсөвт өртөг | 1,382,700,000.00 төгрөг |
| Нийлүүлэх хугацаа | Гэрээний дагуу |
| Төлбөрийн нөхцөл | Урьдчилсан төлбөр |

3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЕХНОЛОГИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Монгол улсын стандарт хэмжил зүйн төвөөс гаргасан Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний чанарын MNS 6861:2020, MNS 0217:2017 стандартын хавсралтаар хүргүүлсэн үзүүлэлтүүдийг хангаж байх.

3.2 Тендерт оролцогч нь Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн чанарын паспорт, Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн хавсралтаар хүргүүлсэн техникийн шаардлагыг хангасан шинжилгээний паспортын хуулбарыг тендерийн баримт бичигт хавсаргасан байх.

3.3 Тендерт оролцогч нь Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн чанарын паспорт, Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн хавсралтаар хүргүүлсэн техникийн шаардлагыг хангасан шинжилгээний паспортын хуулбарыг тендерийн баримт бичигт хавсаргасан байх.

3.4 Нийлүүлэгчийн шатахуун түгээх станцууд нь Монгол Улсын Стандарт хэмжил зүйн газраас гаргасан MNS 4628:2013 /Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага/ стандартыг хангаж байх.

3.5 Шатахуун түгээх станцуудын хэмжих хэрэгсэл (тоолуур) нь Стандарт хэмжил зүйн төвөөр баталгаажсан, хугацаа нь дуусаагүй гэрчилгээтэй байх.

4. НИЙЛҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, бүх аймгийн төв, сумдад шатахуун түгээх станцтай байх.

4.2. Монгол улсын хэмжээнд картаар үйлчлэх ШТС-ын байршлыг ирүүлэх.

4.3. Шатахуун түгээх станц нь 24 цагийн ажиллагаатай байх.

4.4. Бүх ШТС нь Аи-92 автобензин, дизель түлш борлуулдаг байхаас гадна Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад Аи-95 автобензин, Евро 5 дизелийн түлш борлуулдаг байх.

4.5. Цахим картаар нийлүүлэх үнэ нь ШТС-ын жижиглэнгийн үнээс 3%-иас багагүй үнийн хөнгөлөлт олгох.

4.6. Бүх шатахуун түгээх станцуудад картын систем нэвтэрсэн, нэгдсэн сүлжээнд холбогдсон байх.

4.7. Шатахуун түгээх станцаас шатахуун авах тухай Е баримтаа газар дээр нь хэвлэж жолоочид өгдөг байх.

4.8. Тухайн худалдан авалтын дүнгээр нь НӨАТ шивдэг байх.

5. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч нь стандартын шаардлагад нийцсэн, техникийн үзүүлэлтийг хангасан бүх төрлийн шатахууныг баталгаат тоолуураар нийлүүлнэ.

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн

Үйлдвэрлэл, үйлчилгээний газрын ерөнхий менежер,

Үнэлгээний хорооны дарга:



Э.Энх-мөнх

Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө

оруулалт, захиалагчийн албаны Худалдан

авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга:



Э.Уянга

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын

албаны ерөнхий инженер,

Үнэлгээний хорооны гишүүн:



Б.Гантулга

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”

Төрийн бус байгууллагын гишүүн,

Үнэлгээний хорооны гишүүн:



М.Оргил

“ХУД яармаг”

Төрийн бус байгууллагын тэргүүн,

Үнэлгээний хорооны гишүүн:



Ш.Нямбаяр

ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

| № | MNS 0216:2017 | | | MNS 6861:2020 | | | Шинжилгээний аргууд |
|----|--|---------------------|-----|--|---------------------|---------|--|
| | Үзүүлэлтүүдийн нэр | Зөвшөөрөгдөх хэмжээ | | Үзүүлэлтүүдийн нэр | Зөвшөөрөгдөх хэмжээ | | |
| | | ЗУ | Ө | | ЗУ | Ө | |
| 1 | Цетон тоо, багагүй | 51 | | Цетон тоо, багагүй | 45 | | MNS GOST 27768 |
| 2 | Цетаны индекс, багагүй | 46 | | Цетаны индекс, багагүй | | | MNS GOST 27768 |
| 3 | Найрлагын бүрэлдэхүүн, -250 °C-ийн хэмд нэрэгдэх эзэлхүүний %,бага | 65 | | Найрлагын бүрэлдэхүүн, -50% нэрэгдэх хэм, C, ихгүй -95 % нэрэгдэх температур, °C, ихгүй | 280 | | MNS ISO 3405 ⁴ |
| | -350 °C-ийн хэмд нэрэгдэх эзэлхүүний %,багагүй | 85 | | | 360 | | |
| | -95 % нэрэгдэх температур, °C, ихгүй | 360 | | | | | |
| 4 | 40°C дахь кинематик зууралдлага, мм ² /сек | 2.000-4.500 | | 20°C дахь кинематик зууралдлага, мм ² /сек | 3.0-6.0 | 1.8-5.0 | MNS 0480 |
| 5 | Битүү тигелд тодорхойлсон дөл үүсгэх температур,°C, багагүй | 55 | | Битүү тигелд тодорхойлсон дөл үүсгэх температур,°C, багагүй | 40 | 30 | MNS 0333 |
| 6 | Түлшин дэх хүүхрийн массын хувь тг/кг ихгүй K3 K4 | 350 | | Түлшин дэх хүүхрийн массын хувь тг/кг ихгүй K1 K2 | 2000 | | MNS 0470 ¹ MNS 0326 MNS 3543 ГОСТ 32139 ISO 20846 |
| | | 50 | | | 500 | | |
| 7 | Зэс хавтгайн туршилт (50°C-т 3 цаг) | Ангилал 1 | | Зэс хавтгайн туршилт (50°C-т 3 цаг) | Ангилал 1 | | MNS ISO 2160 |
| 8 | Нийт бохирдол, мг/кг, ихгүй | 24 | | Нийт бохирдол, мг/кг, ихгүй | 24 | | MNS 3697 |
| 9 | Хувийн жин, 15°C-т, кг/м ³ | 820-845 | | Хувийн жин, 15°C-т, кг/м ³ , ихгүй | 863.4 | 843.5 | MNS GOST R 51069 ГОСТ 31392 |
| 10 | Булингартан температур, °C, ихгүй | | -16 | | | | MNS ASTM D 2386 MNS GOST 5066 |
| 11 | Шүүгдэх чанарын дээд температур, °C, ихгүй | -20 | - | Шүүгдэх температур, C, ихгүй | -15 | -35 | MNS 5800, MNS 5799 MNS ASTM 36 |

MNS 0216 стандартыг 2017 оны 04 дүгээр сарын 06 ны өдөр баталж 2018 оны 10 дугаар сарын 1-ээс эхлэн мөрдөнө. Евро-5 дизель түлш

MNS 6861 стандартыг 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдөр баталж, 2020 оны 08 дугаар сарын 26-аас эхлэн мөрдөнө. Дизель түлш

АВТО БЕНЗИН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА /MNS 0217-2017/

| № | Үзүүлэлтүүдийн нэр | Зөвшөөрөгдөх хэмжээ | Шинжилгээний аргууд |
|---|---|--|---|
| | | АИ-92 | |
| 1 | Октаны тоо, багагүй: - Шинжилгээний аргаар - Моторын аргаар | 92 83 | MNS GOST R 52946 ГОСТ 32339, ГОСТ 511 ГОСТ 32340, ГОСТ 8226 |
| 2 | Хүхрийн агууламж экологийн ангилалд, мг/кг, ихгүй К3 К4 | 150 50 | MNS 470,ГОСТ 32139 ISO 20846, ISO 20448 |
| 3 | Зэс хавтгайн туршилт (50°C-т 3 цаг) | Ангилал 1 | MNS ISO 2160 ГОСТ 6321, ГОСТ 32329 |
| 4 | Өнгө, гадна төрх | Цэвэр тунгалаг | Нүдээр ажиглах |
| 5 | Нягт, 15°C-т, кг/м ³ | 725.0-780.0 | MNS GOST R 51069 MNS ASTM D 4052 ГОСТ 31072, ГОСТ 31392 |
| 6 | Ханасан уурын даралт, кПа | 35-100 | MNS 3626, MNS GOST 28781 EN 13016-1 |
| 7 | Найрлагын бүрэлдэхүүн ууршилт эзэлхүүний хувь, %, температурын үед -70°C(И70) -100°C(И100) -150°C(И150), багагүй -Буцалж дуусах температур °C, ихгүй -Колба дахь үлдэгдэл эзэлхүүний хувь,%, ихгүй | 215.0 15-50 40-70 75 2.0 | MNS ISO 3405 MNS GOST 22055 |

2017 оны 04 дүгээр сарын 06 ны өдөр баталж, 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөнө